



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 488

Улаанбаатар хот


“Зоос хүрд” ХЗХ-ны салбар нээж ажиллуулах
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 245 дугаарын тогтоолын хавсралтаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 9.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Зоос хүрд” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 455 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул 2013 оны 539 дүгээр тогтоолоор олгосон салбар нээж ажиллуулах зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тогтоол батлагдсантай холбогдуулан салбарын гэрчилгээг хураан авч, холбогдох бүртгэлд өөрчлөлт оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

151800001157